



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 82

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Луус сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7,000,000 /долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй 1,750,000.24 /нэг сая долоон зуун тавин мянган төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй HYUNDAI маркийн портер автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ганчимэг)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг худалдан борлуулж, орон нутгийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх.

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны  
өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт

Луус сумын Засаг даргын Тамгын газрын актлах хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Арлын дугаар	Моторын эзэлхүүн	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Портер автомашин	2002/2012	Kmfhkc7bp 2u596338	2359.D	7,000,000	5,249,999.76	1,750,000.24
Дүн					7,000,000 /долоон сая/ төгрөг	5,249,999.76 /таван сая хоёр зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг далан зургаан мөнгө/ төгрөг	1,750,000.24 /нэг сая долоон зуун тавин мянга хорин төрвөн мөнгө/ төгрөг